

ГОВЬ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 сарын 24-ний өдрийн 11:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулагдав. Хурлыг Говь ХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа даргалж, ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Баяр, Б.Нандин-Эрдэнэ, А.Жаргалмаа, ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хулан, Ж.Оюунчимэг, Ц.Баатарсайхан, Үйл ажиллагаа хариуцсан Тэргүүн Дэд захирал Ч.Солонго, Онлайн хариуцсан Тэргүүн дэд захирал О.Болорбат, Санхүү хариуцсан захирал Г.Сэлэнгэ, Санхүү стратеги төлөвлөлт хариуцсан захирал Э.Тод-Од, Хүний нөөц, захиргаа хариуцсан захирал Н.Тэгшжаргал, Мэдээлэл технологи хариуцсан захирал Э.Уртнасан, Хөндлөнгийн аудитор (Бейкер Тилли Далайван Аудит ХХК) Б.Уянга нар оролцов.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Бид онцгой нөхцөл байдалд хурлаа явуулах шаардлагатай болсныг та бүхэн мэдэж байгаа байх. Дэлхийг хамарсан цар тахал, Ковид-19 улмаас 2020 онд дэлхийн нийтийн эдийн засгийн агшилт 3,5 хувь, Монгол улсын эдийн засгийг 5,2 хувь агшаалаа. Ийм онцгой нөхцөл байдалд бид нар үйл ажиллагаагаа явуулж байгаа. Мөн бид энэ хурлаа цахим талбар дээр явуулах болсонтой холбогдуулан та бүхэнд оршил хийх нь зөв гэж бодож байна. Хурлыг бид үйлдвэрийн газраас шууд дамжуулж байгаа. Энэ хурлыг та бүхэнд хүргэхээр Livestream компани хамтран ажиллаж байна. Бид бүхэн ажлаа эхлүүлэхээсээ өмнө энэ талбараа халдваргүйжүүлэх, ариутгах үйл ажиллагааг бүрэн хийлээ. Хурлыг надтай хамт эндээс шууд хөтлөөд аваад явахаар миний зүүн гар талд, Тэргүүн дэд захирал Ч.Солонго болон миний баруун гар талд ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Нарантуяа нар ажиллана. Бид гурав хоорондын зай барьсан, Livestream компанийн ажиллагсад бүрэн шинжилгээнд хамрагдсан, хоорондын зай барьж байгаа, халдваргүйжүүлэлтийг сайн сахиж байгаа учир дуу хоолойгоо та бүхэнд тод хүргэх, мэдээллийн ойлгомжтой байдлыг бий болгох үүднээс бид бүхэн маскаа аваад ажиллая гэж бодож байна. Хурлаа эхлүүлэхээсээ өмнө хурлыг хүчин төгөлдөр болгодог нэг чухал зүйлийг танилцуулах шаардлагатай байгаа. Тооллогын комиссын дарга Н.Сайнзулыг ирцийн мэдээллийг өгнө үү хэмээн хүсэж байна.

ХУРЛЫН ИРЦИЙГ ТАНИЛЦУУЛАХ

Тооллогын комиссын дарга Н.Сайнзул танилцуулав.

Н.Сайнзул: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Говь ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг мэдээллэж байна. 2021 оны 4 сарын 1-ний өдрөөр тасалбар болгосон хувьцаа эзэмшигчдийн бүртгэлээр, Говь ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо 780,112,500 ширхэг байсан. 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцогчдыг 2021 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөс 4 дүгээр сарын 20-ний өдөр хүртэл бүртгэсэн бөгөөд өнөөдрийн хуралд 689,739,647 ширхэг саналын эрхтэй нийт 136 хувьцаа эзэмшигч оролцож, хурлын ирц 88,42% болсноор Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлын ирц бүрдсэнийг мэдэгдэж байна.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Н.Сайнзул даргад баярлалаа. Хурлын ирц 88,4% байгаа учир хурал өөрөө хүчин төгөлдөр, хурлыг албан ёсоор нээснийг мэдэгдье. Юуны түрүүнд та бүхэнд хурлын дэгийг танилцуулъя. Нэгт хурлын ирцийг гаргаж хурлын даргад мэдэгдэх. Дараа нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээх. Би сая албан ёсоор хурлаа

нээлээ. Хурал цахим явж байгаа учир цахимаар хуралд оролцож байгаа бүх оролцогчдоо та бүхэнд танилцуулах шаардлагатай гэж үзэж байна. Нэгдүгээрт манай ТУЗ-ийн гишүүд бүрэлдэхүүнээрээ орж байгаа. Zoom-р бид бүхэнтэй харилцана. Үүнээс гадна манай захирлууд zoom дээр бэлэн байдлыг хангаад байж байгаа. Энэ бүрэлдэхүүн дотор манай тооллогын комисс бүрэн бүрэлдэхүүнээрээ, мөн манай хөндлөнгийн аудитороор ажилласан байгууллагын төлөөлөл Б.Уянга бас оролцож байгаа гэдгийг мэдэгдэхэд таатай байна. Хурлын дэгийг үргэлжлүүлэн танилцуулъя. Тооллогын комиссыг томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах. Үүний дараа хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу илтгэлүүдийг танилцуулна. Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбоотойгоор асуулт, хариултын хэсэгт бид 15 минутын хугацаа хуваарилсан. Үүний дараа Санал хураалт /15 минут/ товлогдсон байна. Үүний дараа тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэж танилцуулах. Хурлаас гарах тогтоолын төсөлд санал асуулгын дүнг тусган танилцуулж, тогтоолоо баталгаажуулах байдлаар өнөөдрийн хурал өндөрлөх ёстой. Хурлын үргэлжлэх хугацааг бид 2 цаг байх болов уу гэж бодож байна. Тооллогын комисс томилсон тухай тогтоолыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа танилцуулна.

ТООЛЛОГЫН КОМИССЫГ ТАНИЛЦУУЛАХ ***ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа танилцуулав.***

Б.Нарантуяа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тогтоолыг уншиж танилцуулъя. Монгол улс, Говь ХК, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тогтоол, 2021 оны 3 сарын 12-ны өдөр тогтоол дугаар 09, Улаанбаатар хот, Тооллогын комисс томилох тухай. Говь ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахтай холбогдон, тооллогын комиссыг томилох тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 67.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

Нэг. Говь ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай:

Комиссын дарга:	Н.Сайнзул – Дотоод аудитын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Цэцэгбадам – Санхүү бүртгэлийн албаны дарга
Гишүүд:	Т.Мөнхзул – Ахлах аудитор
	Б.Уянга– Хөдөлмөрийн харилцаа хариуцсан албаны дарга

Хоёр. Тооллогын комисс (Н.Сайнзул)-д даалгах нь:

1. Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;
2. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох;
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултад тайлбар өгөх;
4. Санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
5. Хувьцаа эзэмшигчид цахим санал хураалтад оролцох бүртгэлийг хийх;
6. Саналын хуудсыг хайрцагаар мөн цахим хэлбэрээр авах;
7. Саналыг тоолж, энэ тухай тэмдэглэл хөтлөх;
8. Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах.

Тогтоолыг танилцууллаа. Баярлалаа.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Хэлэлцэх асуудал 1-рүү оръё. Говь ХК-ийн 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үр дүнгийн тайланг Тэргүүн дэд захирал Ч.Солонго та бүхэнд танилцуулна. Ч.Солонго захирлыг урьж байна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫГ ТАНИЛЦУУЛАХ

1. Компанийн 2020 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг Тэргүүн Дэд захирал Ч.Солонго танилцуулав.

Ч.Солонго: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Өнгөрсөн 2020 он бид бүгдийн хувьд нэлээдгүй сорилтыг дагуулсан жил болж өнгөрлөө. Цар тахлын үед нөхцөл байдлаа илүү мэдэрч, илүү түргэн шуурхай, уян хатан шийдвэрүүдийг гаргаж, өнгөрсөн арга барил хэв маягаасаа илүү өөрөөр шинээр ажиллах хэрэгцээ шаардлага тулгарсан ийм жил болж өнгөрлөө. Бидний хувьд Говь компанийн маань ирээдүйн үнэ цэнэ, ирээдүйн өгөөж авчрах ирээдүйн хамгийн том боломж болох онлайн худалдаа руугаа бид бүхэн түлхүү анхаарч ажилласан байгаа. Ингээд та бүхэндээ Говь ХК-ийн 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үр дүнгийн тайланг танилцуулъя. Өнгөрсөн онд борлуулалтын нийт орлого 117.1 тэр бум төгрөг байсан. Үүнээс 42%-ийг дотоод борлуулалт, 31%-ийг экспортын борлуулалт, 27%-ийг охин компани буюу онлайн борлуулалт эзэлсэн. Үүнээс харахад бидний борлуулалтын орлогын бүтэц илүү сайн тал руугаа өөрчлөгдөж байгаа харагдаж байна. Учир нь 2019 оны Говь ХК-ийн нийт борлуулалтын орлогын 63%-ийг дотоод борлуулалт дангаараа эзэлдэг байсан бол 2020 он гэхэд 42% болж дийлэнх хувийг нь гадаад зах зээл эзэлж байна. Цэвэр ашгийн хувьд -46.2 тэр бум төгрөг, хөрөнгө оруулалт 0.9 тэр бум, төсөвт төвлөрүүлсэн татвар хураамж 8.3 тэр бум төгрөг, компанийн үнэлгээ 2020 оны 12 сарын сүүлийн байдлаар 150.2 тэр бум төгрөг байлаа. 2020 онд дунджаар 1,939 ажилтантай бид ажилласан. Үйлдвэрлэлийн хувьд сүлжмэл бэлэн бүтээгдэхүүн 954 мянган ширхэг, оёмол бүтээгдэхүүн 49 мянган ширхэг, нэхмэл бүтээгдэхүүн 220 мянган ширхэг, ээрмэл утсыг 226 тонн үйлдвэрлэсэн байна. 916 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын задаргааг та бүхэнд тайлбарлая. Барилга байгууламжид зарцуулсан 243 сая төгрөг буюу энэ ажлыг бид 2019 онд эхлүүлсэн дуусгасан хугацаа 2020 он байсан. Нийгмийн хариуцлагын хүрээнд нөгөө талаасаа Засгийн газрын 73-р тогтоолын дагуу аж ахуй нэгжүүд нь өөрсдийн ашигласан бохир усыг хотын төв байгууламж руу нийлүүлэхээсээ өмнө тодорхой стандартыг хангасан цэвэршүүлсэн байдлаар нийлүүлэх шаардлагатай байсан. Нөгөөтэйгүүр өөрсдийн ашигласан бохир усыг дахин боловсруулж саарал ус болгон ашиглах технологийг хэрэгжүүлээд, урьдчилан цэвэрлэх байгууламжийг барьсан байгаа. Тоног төхөөрөмжид зарцуулсан 273 сая төгрөг нь өмнөх онуудад ээрмэлийн үйлдвэрт хөрөнгө оруулалт хийсэн тоног төхөөрөмжүүдийн зарим нэг тоноглол болон сэлбэг хэрэгслийг худалдаж авсан байгаа. Бусад буюу 399 сая төгрөг нь онлайн зах зээлийг тэлж ажилсантай холбоотойгоор зарим нэг компьютер, программ хангамжийг худалдаж авсан. Биет бус хөрөнгөд юу ордог талаар дурдвал олон улсын зах зээлд гарч байгаа тохиолдолд барааны тэмдэгт буюу оюуны өмчийн асуудал чухал байдаг үүнд зарцуулсан байгаа. Түрүүн хэлсэнчлэн бид бүгд 2020 онд онлайн зах зээл рүү түлхүү анхаарч ажилласан. Өнгөрсөн хугацаанд ямар онцлох ажлууд хийгдсэн талаар товч та бүхэнд танилцуулъя. 2020 оны 1-р сарын байдлаар бид 3 онлайн дэлгүүртэй үйл ажиллагаа явуулж байсан. 2 сард Google компанийн Ази дахь төв оффистой бизнесийн түншлэлээ эхлүүлсэн. 3 сард Английн загвар зохион бүтээгч Мартин Паркертай хамтарч

хавар/зуны коллекцийг гаргаж, анхны онлайн коллекцийнхаа нээлтийг хийсэн байдаг. 5 сард дэлхийн топ маркетингийн компани болох Ogilvy компанитай хамтран ажиллаж судалгаа хийлгэх, брэндингийн ажлаа эхлүүлсэн байгаа. 6 сард Англи болон ОХУ дахь онлайн дэлгүүрүүдээ нээсэн. 7 сард Франц болон Польш улсууд дахь онлайн дэлгүүрүүдийн нээлтийг хийсэн. 9 сард Хятад улс дахь зах зээлийн Tmall болон JD платформуудаар борлуулалтаа хийж эхэлсэн мөн үүний зэрэгцээ Швед болон Норвеги улсууд дахь онлайн дэлгүүрийнхээ нээлтийг хийсэн. 10 сард Хятад улсын WeChat платформ дээр бид бүхэн өөрсдийн албан ёсны дэлгүүртэй болж борлуулалтаа хийж эхэлсэн. 11 сард Англи улсын The Sunday Times сэтгүүл дээр анх удаа Монголын ноолуур Говь ХК-ийн бүтээгдэхүүний сурталчилгааг гаргасан байгаа. Ингээд 2020 оны 12 сарын байдлаар бид бүгд өөрийн гэсэн 9 дэлгүүртэй Хятадын 4 платформтой нийт 13 сувгаар онлайн борлуулалтаа хийж ажилласан. Эдгээр онлайн сувгууд маань дэлхийн газрын зураг дээр харвал ийнхүү харагдаж байна. Онлайн борлуулалтын голлох өөрчлөлтийн талаар товч танилцуулъя. Impression буюу маркетингийн зар сурталчилгаа хайлтын систем дээр нийт 344 сая хүнд хүрсэн байгаа, социал суваг буюу фэйсбүүк инстаграм дээр 175 сая хэрэглэгчид хүрсэн байгаа. Эдгээр хэрэглэгчдээс Session буюу манай онлайн дэлгүүр лүү зочилсон хүмүүсийн тоо хайлтын систем дээр өмнөх оноосоо 5.1 дахин өссөн бол социал сувгууд дээр 6.9 дахин өссөн байгаа. Эдгээр зочилсон зочдоос худалдан авалт хийсэн хувь нь хайлтын систем дээр 1.3 дахин өссөн бол социал сувгууд дээр 3.23 дахин өссөн байна. Нэг худалдан авалтад зарцуулдаг бидний маркетингийн зардал хайлтын систем дээр 50.7% буурсан бол социал сувгууд дээр 49.1% буурсан байна. 2020 онд захиалгын тоо өмнөх жилтэй харьцуулахад 551.3% өссөн. Борлуулалтын үнийн дүн 29.6 тэр бум буюу өмнөх оноос 6 дахин өссөн үзүүлэлттэй байлаа. Онлайн 3 том зах зээл буюу 3 охин компанийн үйл ажиллагааг танилцуулъя. Европын зах зээл 20.8 тэр бум төгрөгийн борлуулалттай ажилласан. Энэ өмнөх оноос 8.5 дахин өссөн үзүүлэлт байлаа. 385 загвараар бараа бүтээгдэхүүнээ борлуулж, өдөрт 7,000 гаруй хүн хандалт хийж байсан. Хойд Америкийн зах зээл анх 2019 оны 9 сард үйл ажиллагаагаа эхлүүлж байсан. 2020 онд нийт 5.7 тэр бум төгрөгийн борлуулалттай ажил өнгөрсөн оноос 4.3 дахин өссөн үзүүлэлттэй байлаа. 334 загвараар бараа бүтээгдэхүүнээ борлуулж, манай дэлгүүр лүү өдөртөө 4,800 гаруй хүн хандаж байсан. Хятадын зах зээл 3.1 тэр бум төгрөгийн борлуулалттай ажиллаж өмнөх оноос 3 дахин өсөлтийг үзүүлсэн. Хятадын зах зээлд 255 загвараар бараа бүтээгдэхүүнээ борлуулж, өдөрт 3,500 гаруй хүн дэлгүүр лүү хандан орж ирсэн байна. Говь брэндийг дэлхийд таниулах борлуулалтаа өсгөх зорилгоор дижитал болон хэвлэмэл олон улсын нэр хүндтэй сонин сэтгүүлүүдэд гарах ажлыг эхлүүлсэн. Их Британи улсын 200 жилийн түүхтэй The Sunday Times сэтгүүл, мөн Telegraph сонин, ОХУ-ын Glamour сэтгүүл, Францын Gala сэтгүүлүүд дээр Говь ХК-ийн бүтээгдэхүүний анхны зар сурталчилгаа хэвлэгдэж гарсан байгаа. Экспортын зах зээлийн хувьд 36 тэр бум төгрөгийн борлуулалттай ажилласан. Өмнөх онтой харьцуулахад 45%-ийн бууралттай байна. Бид дэлхийн 8 улсын 19 хотод 2 франчайз дэлгүүртэйгээр үйл ажиллагаа явуулсан. Дэлхий нийтэд тархсан цар тахлын нөлөөлөл бидний харилцагчид, тэдгээрийн борлуулалт, үйл ажиллагаанд нөлөөлсөн байдал нь бидний экспортын үзүүлэлт борлуулалтад нөлөөлж яалт ч үгүй бууралттай ажиллалаа. Дотоод зах зээлийн хувьд 49.5 тэр бум төгрөгийн борлуулалттай ажилласан энэ нь өмнөх оноос 63%-ийн бууралттай үзүүлэлт байлаа. Гол нөлөөлөл нь жишээлбэл 2019 онд Монгол улсад нийтдээ 1,577 гаруй жуулчид ирсэн байдаг. Үүний 65% буюу 370,000 гаруй жуулчид Говь ХК-р үйлчлүүлж борлуулалт хийсэн байдаг. Гэтэл 2020 оны хил хаасантай холбогдуулан, хөл хориотой холбогдуулан, энэ урсгал зогсож бидний энэ борлуулалт тэг байсан. Үүний хажуугаар Ковид-той холбоотой

дэлгүүрүүд хаагдаж, борлуулалт буурч, борлуулалттай холбоотой үйлдвэрлэл хумигдсан ийм үзүүлэлттэй байлаа. Гэсэн хэдий ч бид зөвхөн дэлгүүрээр борлуулалт хийхгүйгээр Монголдоо ч бас цахим хэлбэр лүү шилжих шийдвэрийг гаргаж, 11 сараас shopru.mn болон toktok цахим худалдааны платформуудаар бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн байгаа. “Говь намар/өвөл 2020” шинэ коллекц танилцуулах арга хэмжээг Галлериа худалдааны төв дээрээ амжилттай зохион байгуулсан. 2020 он хэдий Ковидтой, хөл хориотой жил байсан ч бид бүгдийн хувьд зарим нэг хувьцаа эзэмшигч та бүхэндээ дуулгах ажлыг хийсэн байгаа. Үүний нэг жишээ бол тогтвортой хөгжил буюу “Гурван талт тогтвортой ноолуурын хамтарсан төсөл”-ийг эхлүүлсэн. Энэ төсөл нь Үйлдвэрлэл - Шинжлэх ухаан - Малчид хоорондын уялдаа холбоог бэхжүүлж малын эрүүл мэнд, арчилгаа маллагаа, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хийж гүйцэтгэх, улмаар үржлийн шилмэл хээлтүүлэгчийг үржил селекцийн ажилд ашиглах болон малчдад ямааны ноолуур бэлтгэлийн технологийн зөв дадал эзэмшүүлэх замаар түүхий эдийн чанарыг сайжруулах, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилго бүхий "Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл"-ийг 2020 оны 10-р сараас эхлэн ХААИС-ийн эрдэмтэн багш нар болон малчидтай хамтран хэрэгжүүлж байна. Малчидын төлөөлөл болгон Баянхонгор аймгийн Жинст сумын Хөнөг баг болон Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Асгат багийн нийт 18 малчин өрхийг сонгон авч хамтран ажиллаж байна. Төслийн хүрээнд 2020 онд нийт 21 толгой шилмэл омгийн ухныг сайжруулагчаар сонгон авч малчиддаа хүлээлгэн өгсөн. Мөн өвөлжилтийн бэлтгэлд зориулж өвс тэжээлийн туслалцаа үзүүлээд байна. Цаашид малчдад зориулсан сургалт, зөвлөгөө, малыг эрүүлжүүлэх, малчидыг ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй танилцуулах, харьцуулсан судалгаа хийх, мэдээллийн сан үүсгэх зэрэг ажлууд хийгдэнэ. Бас нэг дуулгах ажил нь ГОВЬ ХК-ний үйлдвэрлэсэн ээрмэл утас нь Швейцарь улсад төвтэй OEKO-TEKC байгууллагын 1992 оноос эхлэн дэлхий нийтэд мөрдөгдөж байгаа “STANDARD 100 by OEKO-TEX” шаардлагыг хангаж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанарын гэрчилгээг гардан авсан билээ. Энэхүү гэрчилгээ нь ГОВЬ ХК-ийн үйлдвэрлэсэн ээрмэл утас ямар нэг химийн хортой бодис агуулаагүй бөгөөд хүний эрүүл мэндэд аюулгүй, найдвартай гэдгийг хэрэглэгчдэд харуулах баримт болж байгаа юм. Монгол улс даяараа маш хурдан цахим руу шилжиж байгаа. Говьчууд бидний хувьд ч мөн энэ ажлыг эхлүүлээд явж байна. Компанийн нэгдсэн санг үүсгэж, мэдээлэл хадгалалт, дамжуулалтын аюулгүй байдлыг дээд зэргээр хангаж, ажилчдын бүтээмжийг ахиулах, тэдгээрийн чадварыг дээшлүүлэх, технологи, программын цогц шийдлээр цаг үетэйгээ хөл нийлүүлэн хэрэглэгчдэд илүү ойртож хамтран ажиллах, хоорондын уялдаа холбоог сайжруулах замаар үр өгөөжийг нэмэгдүүлэн бүх шатны ажилчид болон харилцагч, хэрэглэгчдийг мэдээллээр түргэн шуурхай хангаж байх болно. 2020 онд цар тахлын үед эрсдэлийг бууруулах менежментийг хэрхэн хэрэгжүүлж ямар арга хэмжээ авч ажилласан талаар товч танилцуулъя. Бид гамшгаас хамгаалах штабын баг бүрэлдэхүүнийг томилон, эрсдэлийн менежментийг дараах 4 зарчмын дагуу хэрэгжүүлсэн. Үүнд: хүнээ бодох, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, нийгмийн хариуцлагаа ухамсарлах, аль болох боломжоороо үйл ажиллагааны тогтвортой байдлыг хадгалах. Мэдээж бид Засгийн газар, НОК, ЭМЯ-ны шийдвэр, зөвлөмжийг мөрдөж, гамшгаас хамгаалах штаб баг бүрэлдэхүүнээрээ дамжуулан үйлдвэр, компани, бүх газар нэгжүүдэд удирдамж зааварчилгаа өгч ажилласан. Ажилтнуудыг ажиллуулахдаа эрсдэлийг үнэлэх асуумжыг бөглүүлэн ажиллуулах эсэхийг шийдэж байсан. НОК-с гарсан заавар чиглүүлгийн дагуу олон хүний бөөгнөрөл үүсгэхгүй тулд, хоорондын зай бариулах, эсвэл богиноссон цагаар ажиллуулах, зайнаас ажиллуулах, ээлжийн хуваарь зохион байгуулалтад оруулах арга хэмжээг авч ажилласан. Бодитоор компанийн

байранд ирж ажиллах болсон ажилчдыг ажлын байр луу нэвтрүүлэхдээ тусгай зориулалтын ариутгалын хаалгаар оруулж, биеийн халууныг хэмжих, мөн өдөр тутмын нэг удаагийн хамгаалах хэрэгслээр хангаж ажилласан. Мэдээж зохих ёсны халдваргүйжүүлэлт, ариутгалын ажлыг 2 долоо хоног тутам, мэргэжлийн байгууллагуудтай хамтран бүрэн ариутгал хийж ажилласан. Ингээд 2020 онд Говь ХК Топ 100 ААН шалгаруулах арга хэмжээнд 19 дүгээр байранд шалгарсан байгаа. Мөн та бүхэнд дуулгах онцлон үйл явдал гэвэл Монгол улсын төрийн дээд шагнал болох Сүхбаатарын одонгоор Говь ХК 2020 онд шагнагдсан. Миний зүгээс та бүхэнд танилцуулах тайлан үүгээр өндөрлөж байна. Төгсгөлд нь та бүхэндээ хандаж хэлэхэд өнөөдрийн хүртэл Говь ХК-тай хамтдаа байж, өнөөдрийг хүртэл үнэнч хувьцаа эзэмшигч байсан та бүхэндээ баярлалаа гэж хэлмээр байна. Миний бие баг хамт олноо удирдан зохион байгуулж, манлайлж байгаа Тэргүүн дэд захирлын хувьд өнөөдрийн үүсээд байгаа нөхцөл байдлыг ирээдүйн маш том боломж, ирээдүйн сайн сайхан зүйлийн өмнөх түр зуурын сорилт, нөгөө талаасаа суралцах маш том боломж гэж харж ажиллаж байгаа. Бидний хувьд 2021 оны сүүл гэхэд алдагдлаа нөхөж, 2022 он гэхэд 46 тэр бумын ашигтайгаар ажиллана гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Цаашлаад хэлбэл Говь ХК дэлхийд гарсан дэлхийн хэмжээний компани болно гэдэгт миний бие огт эргэлзэхгүйгээр 100% итгэлтэйгээр ажиллаж байгаа. Энэхүү ажлыг хийхэд компанийн үнэт зүйл болсон 1,500 ажилчид мөн манай хамт олондоо баярлаж байгаагаа илэрхийлье. Анхаарал хандуулан сонссон та бүхэндээ ахин баярлалаа.

2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Солонго захиралдаа баярлалаа. Тайлангаас та бүхэн цар тахлын үед гүйцэтгэх удирдлагын баг хойшоо суугаагүй, байгаа боломжоо бүрэн дүүрэн ашигласан, маш шаламгай, хурдтай ажиллахыг эрхэмлэсэн, магадгүй ирээдүйн стратеги, хөгжлийн суурийг нэлээн сайн тавьсан, энэ байдлыг та бүхэн анзаарсан байх. ТУЗ-ийн зүгээс хэдэн зүйл дээр та бүхний анхаарлыг тусгайлан хандуулмаар байна. Дэлхий нийтээрээ цахим шилжилтийг хийсэн байгаа ялангуяа борлуулалтын сувгуудаа бид цахим талбар луу гаргасан. Энэ дээр борлуулалтын орлогын бүтцэт нэлээн том өөрчлөлт орсныг та бүхэн харж байгаа байх. Бас бид нөгөө талдаа мэдээллийн систем, мэдээллийг удирдах үйл явцдаа SAP системийг хэрэгжүүлээд удирдлагын системийн цогц байдлаар технологи үндсэн үйл ажиллагаанд орж ирж байгаа дэлхийтэй хөл нийлүүлэх боломж гарч ирлээ. Мэдээж бид олон улсын зах зээлийг баримжаалж байгаа учир энэ зах зээлүүдээ таних, ажиллаж сурах нэлээдгүй том сорилттой жил байсан. Орлого багатай асуудал нэлээн ихтэй байсан ч хойшоо суусангүй маш хурдтай шаламгай ажиллалаа гэж бид харж байна. Мөн мэдээж нийгэмдээ үйл ажиллагаа эрхэлж байгаа талаар тогтвортой хөгжлийн чиглэлээр үзэл баримтлал дээр ерөөсөө хойшоо суугаагүй гэдгийг та бүхэн бас анзаарсан байх. Тогтвортой хөгжлийн чиглэлээр нэлээн том төсөл хэрэгжүүлээд явж байгаа, Энэ нь эргээд ирээдүйн Говь-ийн дүр төрхийг тодорхойлох, бас нэг чухал хэсэг болох болов уу гэж харж байна. Ингээд манай ТУЗ-ийн зүгээс Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2020 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж дүгнэж байна. Ингээд хурлын гуравдугаар хэсэг рүү шилжье. Хувьцааны үнэ, ногдол

ашгийн талаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа танилцуулна, Нарантуяаг урьж байна.

3. Хувьцааны үнэ, 2020 оны ногдол ашгийн талаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа танилцуулав.

Б.Нарантуяа: Та бүхэнд 2020 оны хувьцааны үнэ болон ногдол ашгийн талаар мэдээлэл хүргэе. 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон үзүүлэлтүүдийг та бүхэнд танилцуулъя. Хувьцааны үнийн хувьд хамгийн өндөр үнэ 291 төгрөг байсан, хамгийн бага үнэ 164 төгрөг байсан байна, дунджаар 2020 оны хувьцааны үнэ 206 төгрөг байсан байна. Арилжаалагдсан тоо ширхгийн хувьд танилцуулбал хамгийн ихдээ өдөрт 272,232 ширхэг арилжаалагдсан, хамгийн багадаа өдөрт 83 ширхэг арилжаалагдсан байна, дунджаар өдөрт 15,430 ширхэг арилжаалагдсан ингээд нийтдээ 2020 онд 3,811,314 ширхэг хувьцаа арилжаалагдсан байна. Арилжааны үнийн дүнг төгрөгөөр илэрхийлбэл нийтдээ 780,044,366 төгрөгийн арилжаа хийгджээ. 2020 оны 12 сарын 31-ний байдлаар манай компанийн үнэлгээ 150,171,656,250 төгрөг байна энэ нь өмнөх оноос 28.7%-ийн бууралттай байна. Ерөнхийдөө 2019 болон 2020 оны үзүүлэлтүүдийг харвал дийлэнх үзүүлэлтүүд буурсан хандлагатай байна. 2020 оны ногдол ашгийн хувьд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн дугаар 05 тоот тогтоолын дагуу 2020 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. Та бүхэнд шийдвэрийг танилцууллаа, баярлалаа.

4. ТУЗ-ийн 2020 оны ажлын тайланг ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Б.Нарантуяа нарийн бичгийн даргад баярлалаа. Одоо хурлын дөрөвдүгээр хэсэг рүү шилжье. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 онд хийсэн ажил, үйл ажиллагааны тайланг танилцуулахад бэлэн болоод байна. Говь ХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн дэлгэц дээр харагдаж байна. Бид бүхэн есүүлээ байдаг. Хараат бус таван гишүүнтэй, ердийн дөрвөн гишүүнтэй ийм бүтэцтэй бид бүхэн ажиллалаа. ТУЗ-ийн үндсэн үйл ажиллагааны чиглэл, ТУЗ үндсэн үүргээ хэрэгжүүлэхдээ хяналт тавихдаа стратегийн чиглэлээр гүйцэтгэх удирдлагын багаа хангахдаа дороо 3 хороодын үйл ажиллагааны тусламжтайгаар үндсэн үйл ажиллагаа хэрэгжсэн. Үүнд эрсдэл аудитын хороо, цалин урамшууллын хороо, нэр дэвшүүлэх хороо үүний хажуугаар эрсдэлийн удирдлагын баг дотоод аудитын хэлтэстэй нягт уялдаа холбоотой ажилладаг. Засаглалын тогтолцооны хувьд бид уламжлалт сайн засаглалын зарчмуудыг шингээсэн ийм бүтэцтэй нэлээн хэдэн жил үйл ажиллагаа явуулж байгаа. ТУЗ-ийн үндсэн үйл ажиллагааны тайланг танилцуулахад та бүхэн энэ тоог хараад бас нэгийг бодох болов уу гэж бодож байна. Ээлжит хурал 7 байх байсан гэхдээ бид 15 удаа ээлжит бусаар хуралдсан байгаа. 2020 онд ТУЗ нийт 22 удаа хурлаар үндсэн үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байна. Бидний баталсан тогтоолыг тоогоор нь харвал компанийн дотоод үйл ажиллагаатай холбоотой 9 тогтоол, санхүүжилттэй холбоотой 12 тогтоолыг гаргаж байгаа нь үндсэндээ ямархуу жил болоод өнгөрсөн байгааг та бүхэн ойлгож байгаа байх. Санхүүгийн хувьд тогтвортой байдлыг хангах, үндсэн үйл ажиллагааны хувьд хүнээ дээдлэх, хамт олноо чухал гэж харах, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа хэрэгжүүлэх гэдэг чиглэлээр нэлээдгүй шийдвэрүүдийг гаргаж ажилласан болно. Эрсдэл аудитын

хорооны бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя. ТУЗ-ийн хурал бүр дээр манай хороодын хийсэн ажлууд танилцуулагддаг. Үүний дагуу шаардлагатай тохиолдолд ТУЗ шийдвэр гаргадаг. Мэдээллийг цаг тухай бүрд нь ойлгомжтой байдлаар авахыг хичээж ажилладаг. Эрсдэл аудитын хороо 3 хүний бүрэлдэхүүнтэй даргаар Б.Нандин-Эрдэнэ ажилладаг, гишүүдэд Д.Хулан захирал, хараат бус гишүүн А.Жаргалмаа нар ажилласан байгаа. 2020 онд нийт 4 удаа хурал хийж 17 асуудлыг хэлэлцсэн байна. Хороо чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 11 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч хяналт тавьж ажилласан байна. Уламжлалт чиг үүргийнхээ дагуу хараат бус аудитороос өгсөн санал зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааг чиглүүлэх, хянах ажлуудыг хийхээс гадна, 2020 оны онцлог цар тахалтай үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа, олон хүний эрүүл мэнд, ковидтой холбоотой компанийн мөрдөж хэрэгжүүлж байгаа ажилд онцгой анхаарал хандуулж энэ чиглэлд зөвлөмж өгч ажилласан. Нэр дэвшүүлэх хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Баяр, гишүүдээр миний бие ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа болон ердийн гишүүн Ц.Баатарсайхан захирал байдаг. Бид 2020 онд 2 удаа хуралдсан, 6 асуудлыг хэлэлцсэн. Чиг үүргийнхээ хүрээнд 8 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч хяналт тавьж ажилласан. Удирдлагын багийн хагас жилийн болон жилийн тайлантай танилцсан, тус тайланд өгсөн Гүйцэтгэх захирлын дүгнэлттэй танилцсан. ТУЗ-өөс өгч байгаа стратегийн чиглэл тавьж байгаа хяналтыг ямархуу түвшинд хийж гүйцэтгэж байгаа, удирдлагын багийн чанар чансаа хэр байгаа талаар жилд 2 удаа мэдээлэл авдаг учир хяналт боломжийн түвшинд хэрэгжүүлсэн гэж өөрсдөө үзэж байна. Эрх бүхий албан тушаалтнуудын удирдах, манлайлах, багаар ажиллах энэ чадвар дээр онцгойлон анхаарал хандуулж, хэдийн хэцүү жил байсан ч нэр дэвшүүлэх хорооны зүгээс сургалт орсон байгаа. Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүнд даргаар миний бие, гишүүдээр хараат бус гишүүн Такэши Камбэ, ердийн гишүүн Ж.Оюунчимэг нар байдаг. 2020 онд 2 удаа хуралдаж, 7 асуудлыг хэлэлцсэн. Чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 3 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч, хяналт тавьж ажилласан. Хорооны үндсэн үүрэг нь нийт зардлын нэлээдгүй том хэсгийг татаж байдаг цалин урамшуулал болон нийгмийн бодлогын хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаануудын үр дүн ямар байгаа, зардал зарцуулалт ямар байгааг төлөвлөсөн үзүүлэлтийн хүрээнд байгаа эсэхт бил онцгой анхаарал хандуулдаг. Мөн компанийн соёлын болон ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг бид байнга ярилцаж, үүний дагуу тодорхой зөвлөмжүүдийг өгч ажилладаг. Хороо чиг үүргийнхээ хүрээнд цалин урамшууллын гүйцэтгэлд бүрэн хяналт тавьж ажилласан. Ирэх жилийн цалин урамшууллын төсвийг баталсан. Үндсэндээ олон хүн ажиллуулж байгаа байгууллагын хувьд тодорхой ойлголттой, хамгийн сүүлийн үеийн мэдээлэлтэй байж ажиллаж чаддаг гэсэн дүгнэлтээр хороодын тайланг дуусгая. Засаглалын үнэлгээг бид сүүлийн 4 жил тасралтгүй хийж байна. Ажлаа хийж байгаа хүмүүс болоод байгаа гэж бодоод байдаг гэтэл нарийн шүүлтүүрээр ороод бидний ажил ямар түвшинд хэрэгжиж байгааг, алдаж онож байгаа зүйлүүд, цаашид сайжруулах зүйлүүд, боломжууд, нөөц бололцоонууд юу байгааг, хаана явж байгаагаа тодорхой ойлгомжтой болгох үүднээс энэ үнэлгээг хийдэг. Үр дүнгээ бид МХБ-ийн вэб сайт дээр байршуулдаг. Энэ мэдээлэл манай хувьцаа эзэмшигч нарын хувьд нэлээн чухал мэдээллийн тоонд орох болов уу гэж бодож байна. 2018,2019,2020 оны гүйцэтгэлийг та бүхэн харж байгаа байх. 2018 онд 90.6%-р үнэлэгдэж байсан бол 2019 онд үнэлгээ бага зэрэг буурч 86%-руу орсон. Үүний шалтгаан нь анх удаа бид засаглалын үнэлгээг дотоод аудитын хэлтсээр үнэлүүлсэн. Бага зэрэг хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх оролдлого хийгдэж үнэлгээ бага зэрэг буурсан гэхдээ үүнийг бид сайн зүйл гэж хараад сайжруулах шаардлагатай чиглэлүүдээ нэлээн тодорхой болгосон байгаа. 2020 онд бол ТУЗ-ийн түвшинд гүйцэтгэсэн. Үнэлгээ 89%-тай энэ нь үндсэндээ Говь ХК-ийн засаглал сайн засаглалтай буюу боломжийн түвшинд ажиллаж байна гэж үнэлэгдлээ. Үүнээс гадна ТУЗ дотроо гишүүдийн үнэлгээг жил бүр хийж явдаг. Ажлаа үнэлэх, тасралтгүй сайжруулах боломжтой ийм чухал ажил байдаг.

Энэ хоёр судалгааны үндсэн дээр ТУЗ дараа жил ямар ажил хийх вэ, бид нарын болоод байгаа зүйл юу вэ, бүтээсэн байгаа үнэ цэнэ юу вэ цаашид аль чиглэлээр бид өөрсдийгөө илүү сайжруулах илүү хөгжүүлэх шаардлагатай байгааг гаргадаг. Үүний хүрээнд дараах чиглэлүүдийг нэлээн тодорхой болгож гаргаж байгаа. ХЭ-ийн ээлжит хурлын зар болон материалыг хувьцаа эзэмшигчдэд аль болох цахим хаягаар хүргэдэг болох, цахим харилцааны боломжийг улам сайжруулах. Энэ бол 2021 онд хийж хэрэгжүүлэх нэг чухал чиглэл байна. Олон улсын сайн туршлагыг судалж компанийн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн агуулгыг сайжруулах талаар нэлээн нарийн ажлуудыг хийхээр төлөвлөж байгаа (одоогийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчдын хэрэгцээ шаардлагад нийцэх). Дотоод мэдээллийн аюулгүй байдлыг хангах тал дээр тавих хяналтын тогтолцоог илүү сайжруулах шаардлага байна. Учир нь мэдээллийн технологи нэлээн нарийн орлоо, цахимаар ажиллаж байна, цахим тавцан өөрөө түргэн шуурхай ажиллах боломжийг өгч байгаа боловч аюулгүй байдлыг хангах асуудал хуучин арга хэрэгсэл шаардлага хангахгүй ийм байдал руу орж байгаа. Компани дотоод хяналтын бодлогыг шинэчлэн боловсруулах ажлыг ковид буюу цахим шилжилттэй холбоотой уялдаж гарч ирж байна. ХЭХ-ийг долоо хоногийн амралтын өдөр зохион байгуулдаг болох. Тэгээд ч өнөөдөр хурал маань хагас сайн өдөр буюу амралтын өдөр болж байна. Ингэснээр хувьцаа эзэмшигчдийг өргөнөөр оролцуулж, эрхээ эдлэх боломжийг илүү олгох юм, жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах, эрхийг дээдлэх, чухалчлах асуудал дээр энэ талын үйл ажиллагаа нэлээн дэм болох болов уу гэж бодож байна. Мөн нэгэн сонирхолтой судалгааг Нээлттэй Нийгэм Форумас гаргасан байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зохион байгуулалт ямархуу түвшинд явж байгааг үнэлсэн ийм судалгаанд манай Говь ХК хамрагдсан байдаг. Бид хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулж байгаа байдлаараа 3.9 оноо буюу 78%-ийн үнэлгээ авсан. Тоог нь харахаар сайнгүй харагдаж байж магадгүй. Гэхдээ үнэлэгдсэн хувьцаат компаниудын хувьд нэгдүгээрт жагссан ийм онцлогтой. Гэхдээ үүнд онгирох эсвэл бахдахаас илүүтэйгээр эндээс гарсан зөвлөмжүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулахдаа цаашид анхаарах, сайжруулах чиглэлүүдийг үйл ажиллагаандаа тусгана гэж бодож байна. Хөндлөнгийн газрын судалгааг та бүхэнд танилцуулж байгаа нь би өөрийгөө магтах, ТУЗ өөрийн хийсэн ажлын өөдтэйг харуулах нь зүй ёсны хэрэг болов ч хөндлөнгөөс бид нарыг ингэж үнэлж байгаа, бид нарын ажил олон улсын шаардлага, манай зохицуулагч байгууллагуудын шаардлагад ямархуу байдлаар нийцэж байгаа талаар нэлээн дэлгэрэнгүй мөн хараат бус мэдээлэл болох болов уу гэж энэ мэдээллийг та бүхэнд өгч байгаа юм шүү. Үүгээр миний танилцуулах тайлан өндөрлөж байна. Анхаарал тавьсанд баярлалаа. Хурлын дараагийн хэсэг болох асуулт хариултын хэсэг эхлэхэд бэлэн болоод байна. Бид үүнд 15 минутын хугацаа зарцуулна гэж бодож байна.

5. АСУУЛТ ХАРИУЛТ

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож буй нийт хувьцаа эзэмшигчиддээ энэ өдрийн мэнд хүргэе. Хувьцаа эзэмшигчдээс ирсэн дараах 7 асуултад миний бие өөрийн биеэр хариулахад бэлэн боллоо.

Асуулт 1. Компани цаашид ашигтай ажиллах уу?

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Хариуцлагатайгаар хариулахад ашигтай ажиллана. Амьдралд хэрэв гэдэг үг байдаггүй болов ч хэрэв 2020 онд Ковид гараагүй байсан бол Говь ХК 250 тэр бум төгрөгийн борлуулалт хийж, ашигтай ажиллах байсан. Мөн 2021 онд 300 тэр бум төгрөгийн борлуулалт хийж, жилд өөрийн борлуулалтаа 25%-

р өсгөж, ашгийнхаа 40%-ийг хувьцаа эзэмшигчиддээ тараах төлөвлөгөөтэй байсан хэдий ч дэлхий даяар тархсан цар тахлаас болж боломжгүй болсондоо уучлал хүсэж байна.

Асуулт 2. Хувьцааны үнэ өнгөрсөн жил их унасан, одоо дөнгөж 200 гаруй байна. Цаашид үнэ өсөх үү?

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Өнөөдрийн байдлаар Говь ХК-ийн үнэ 240 төгрөг байгаа. Энэ нь оны эхэнтэй харьцуулахад 25%-ийн өсөлттэй байна. Цаашид манай хамт олон улам үнэ цэнэтэй компани байхын төлөө хичээж ажиллана.

Асуулт 3. Сүүлийн жилүүдэд ногдол ашиг тараагаагүй. Үүний шалтгаан? Мөн 2020 оны үйл ажиллагаатай холбоотой ногдол ашиг хуваарилах уу?

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Харамсалтай нь цар тахлын улмаас 2020 оны санхүүгийн үзүүлэлтүүд 45%-р буурч, алдагдалтай ажилласан тул ногдол ашиг тараахгүй байхаар ТУЗ-өөс шийдвэрлэсэн. Харин цар тахлын байдлаас хамаараад бид бүхэн 2021 онд ядаж 2019 оны түвшинд хүрэхийн төлөө хичээж ажиллаж байгаа. Харин 2022 оноос 46 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж үүний 40%-ийг хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг тараахаар хичээж ажиллаж байна.

Асуулт 4. Бүтээгдэхүүний үнэ өндөр байдаг ч ашиггүй ажиллаж байна. Үүний шалтгаан?

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Манай бүтээгдэхүүний үнэ түүхий эдийн үнэтэйгээ харьцуулахад, дэлхийн зах зээл дээрх үнэтэй харьцуулахад тийм өндөр үнэтэй гэж бодохгүй байгаа. Олон улсын зах зээл дээр ялангуяа онлайн худалдаагаар борлуулж байгаа үнэтэй харьцуулахад манай дотоод үнэ бол хоёр дахин хямд байгаа. Мөн нэмээд хэлэхэд 2022 онд компани ямар ч өр зээлгүй компани болж, 46 тэр бум төгрөгийн ашигтай ажиллах болно.

Асуулт 5. Ковид-19 дэлхий нийтэд тархсан, хилээ хаасан энэ цаг үед компани ОУ-д борлуулалтаа хэрхэн хийж ажиллаж байгаа вэ? Дэлхий хэдэн оронд борлуулж байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Цар тахлын үед бидний олон улсад онлайн, франчайз, салбар дэлгүүрүүдээр дамжуулан хийсэн борлуулалт 2020 оны нийт борлуулалтын 58%-г бүрдүүлсэн байна. Бид 13 онлайн дэлгүүр, 24 франчайз дэлгүүр, 1 салбар дэлгүүрээр дамжуулан дэлхийн 60 гаруй улсад борлуулалтаа хийн ажиллаж байна.

Асуулт 6. Ковид-19 манай оронд тархаж орон нутаг руу орж гарах хөдөлгөөн хаасан энэ үед түүхий эдийн татан авалтыг хаанаас, хэр хэмжээнд хийхээр төлөвлөж байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: 2020 онд цар тахлын улмаас ноолуурын дундаж үнэ 60,000 төгрөг болтлоо буурсан. Бид энэ үед 655 тн ноолуур буюу 40 тэр бум төгрөгөөр түүхий эд бэлтгэсэн. 2020 онд цар тахалтай холбоотойгоор үйлдвэр төлөвлөсөн тоо хэмжээнд хүрч ажиллаагүй тул 2021 онд нэмж бэлтгэх шаардлагагүй. Өнөөдөр 1 кг ноолуур 120,000 төгрөг байна. Бид өнгөрсөн жил 60,000 төгрөгөөр түүхий эдээ бэлтгэж чадсан гэж бодвол үнийн зөрүүнээс бид 40 тэр бум төгрөг хэмнэсэн гэж ойлгож болно.

Асуулт 7. Ойрын жилүүдэд бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлж борлуулах талаар, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэхээр гаргасан төлөвлөгөө бий эсэх?

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Говь ХК өнөөдрийн байгаа суурилагдсан хүчин чадал жилд 2.5 сая ширхэг байгаа. Бид 2026 онд дэлхийн зах зээлд нийт 2,000 тн

ноолуур худалдан авч, 5 сая ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үүний 1 сая бүтээгдэхүүнийг Монголынхоо зах зээлд, 4 сая бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээл дээр борлуулахаар төлөвлөгөө зорилт тавьсан байгаа. Анхаарал хандуулж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа идэвхтэй оролцож байгаа нийт хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултад манай Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан хариулт өглөө. Баатарсайхан захиралдаа баярлалаа. Хурлын дараагийн хэсэг рүү шилжье. Одоо санал хураалт нээгдэж байгаа. Та бүхэн санал хураалтын удирдамжтай сайн танилцаарай. Санал хураалтын удирдамж видео хэлбэрээр та бүхэнд хүрнэ.

6. САНАЛ ХУРААЛТ

Санал өгөх санамжийг видео бичлэгээр танилцуулан санал хураалтыг эхлүүлсэн бөгөөд санал хураалт нийт 15 минут үргэлжлэв.

Б.Нарантуяа: Хувьцаа эзэмшигчиддээ нэг зүйлийг анхааруулъя. Өнөөдөр бид хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар зөвхөн нэг асуудлыг хэлэлцэж баталж байгаа. Тэгэхээр та бүхэн нэг асуудал дээр саналаа өгнө. Санал өгөхдөө та бүхэн нэг удаа манай vote.mn гэсэн хуудас руу хандах боломжтой. Хувьцаа эзэмшигчдээс ирсэн санал хүсэлтийн дагуу бид санал хураалтын хугацааг 10 минутаар сунгаж байна. Та бүхэн зааварчилгааг сайтар үзэн саналаа өгнө үү. Баярлалаа.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Хүндэт хувьцаа эзэмшигч та бүхний санал өгөх хугацаа албан ёсоор дууслаа. 15 минутын дараа эргээд уулзъя. Энэ хугацаанд манай тооллогын комисс дүнгээ нэгтгэх ажилтай байна.

7. САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ НЭГТГЭХ

Тооллогын комисс цахим системээр ирсэн санал хураалтын дүнг нэгтгэв.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Санал хураалтын дүнг нэгтгэх дээр тодорхой цаг алдлаа. Гэхдээ хувьцаа эзэмшигч болгоны саналыг санал хураалтад тусгах үүднээс хүлээцтэй хандахаас өөр арга байсангүйг та бүхэнд мэдэгдье. Санал хураалтын дүнг танилцуулна уу хэмээн тооллогыг комиссын дарга Н.Сайнзулыг урьж байна.

8. САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ

Тооллогын комиссын дарга Н.Сайнзул танилцуулав.

Н.Сайнзул: 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын дүнг та бүхэнд танилцуулъя. Нийт ирүүлсэн саналын тоо 56 буюу 689,338,249 ширхэг саналын эрх буюу энэ нь нийт саналын эрхийн 99.94% байна. Үүнээс шуудан брокероор ирүүлсэн саналын тоо 689,102,315 ширхэг буюу 99.90% байна. Онлайнаар ирүүлсэн саналын тоо 52 буюу 235,934 ширхэг буюу 0.034% байна. Нийт хүчинтэй саналын тоо 689,338,249 ширхэг буюу 99.94% болсон байна. Хэлэлцсэн асуудлын хувьд санал хураалтын дүнг танилцуулахад 2020 оны Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай асуудал дээр зөвшөөрсөн 689,338,249 ширхэг буюу 100%-ийн саналаар баталлаа. Татгалзсан санал 0, түдгэлзсэн санал 0 байна.

Ингээд 2020 оны Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсан болно.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Сайнзул даргад баярлалаа. Санал хураалтын үр дүнг та бүхэнд танилцууллаа. Энэ хурлаас гарах тогтоолын төслийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа танилцуулна.

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай.

Б.Нарантуяа: Та бүхэнд тогтоолыг танилцуулъя. Говь ХК, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол. 2021 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр. Дугаар №01.

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.9.10 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2021 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Говь ХК-ийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Хавсралт 1 ёсоор баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.ГЭРЭЛМАА

Хавсралт 1:

ГОВЬ ХК-ИЙН -2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Говь ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2020 оны зорилтуудын талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Сайн засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдлөг болгож, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан 2020 оны бизнес төлөвлөгөө нь компанийн нийт борлуулалтын орлогыг өмнөх оноос 27% өсгөх, нийт ажилтны тоог тогтвортой түвшинд байлгаж, шинээр Канад, Австрали, Япон, Орос, Энэтхэг болон Казакстаны зах зээлд нэвтэрч нийт 200 мянган эцсийн бүтээгдэхүүнийг хилийн чанд дахь өөрийн дэлгүүр болон цахим борлуулалтын сувгаар борлуулах, Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO45001:2018 болон Байгаль орчны удирдлагын

тогтолцооны ISO14001:2015 стандартын баталгаажуулалтуудыг авах, олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлыг дахин идэвхжүүлэхэд тус тус чиглэсэн билээ.

Говь ХК 2020 онд 117,1 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж, бизнес төлөвлөгөөний биелэлт 44 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Гадаад борлуулалт 2020 онд 36 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 30.8 хувь, дотоод борлуулалт 49.5 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 42.2 хувь, онлайн борлуулалт 31.6 тэр бум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 27 хувьд хүрчээ.

Мөн тайлант жилд 655 тонн түүхий эд бэлтгэж, нийт 916.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 515.6 сая төгрөг буюу 56.3% нь тоног төхөөрөмж, барилга байгууламжийн тохижуулалтад, 271.4 сая буюу 29.6% нь компьютер болон программ хангамжид, 129 сая буюу 14.1% нь барааны тэмдэгт болон тавилга эд хогшилд тус тус зарцуулагдсан байна.

Иймд Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2020 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяадаа баярлалаа. Говь ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн хурал үүгээр өндөрлөж байна. Идэвхтэй оролцоотой байсан, бид бүхнийг сонирхож оролцсон бүх хувьцаа эзэмшигч нартаа эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэе. Үйлдвэрийнхээ хамт олон, гүйцэтгэх удирдлагын баг, бид нарыг дэмжиж ажилласан Livestream компанийн хамт олон, манайхтай холбоотой бүх хүмүүстээ, хэрэглэгч нартаа сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Баярлалаа та бүхэндээ, ажлын өндөр амжилт хүсэе.

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хурал 13 цаг 09 минутад өндөрлөв.

Хурлын даргалагч:

ТУЗ-ийн дарга

Д.ГЭРЭЛМАА

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Б.НАРАНТУЯА